# ХААН СОЁМБО АУДИТ ХХК

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2023/39/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2023 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Даваанямб
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Гүйцэтгэсэн аудитор: Н.Бадамханд
Утас: 99042699 Цахим хаяг: khaan.soyombo.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ ........ 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........ 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 10
3. АУДИТЫН ТАЙЛАН ........ 11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ........ 11
3.2 Байгууллагын гадаад дотоод орчин ........ 11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ........ 11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 12
3.5.1 Төсвийн төлөвлөлт ........ 12
3.5.2 Төсвийн гүйцэтгэл ........ 12
3.6.3 Нэмэлт төсөв ........ 12
4. АУДИТЫН ТАЙЛАН ........ 13
4.1 Ерөнхий зүйл ........ 13
4.2 Материаллаг байдал ........ 13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ 13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 14
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд ........ 14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 14
4.5.1 Завсрын аудитын талаар ........ 14
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн ........ 14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ........ 14
5.1 Төлбөрийн акт ........ 14
Төлбөрийн акт тогтоогоогүй болно. ........ 14
5.2 Албан шаардлага ........ 14
Албан шаардлага өгөөгүй болно. ........ 14
5.3 Зөвлөмж ........ 14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ........ 15

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| БТСУХ | Биеийн тамир спортын улсын хороо |

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.24 № 01/144

танай ______________ -ны № ______________ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР,
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА
Б.БАЯРСАЙХАН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Иргэдийн спортын наадмаар зохион байгуулагдсан тэмцээн, уралдааны шагналын мөнгө арилжааны банкаар дамжигддаг бөгөөд 1 хүний данс буруу учраас арилжааны банканд үлдэгдэлтэй байна.

**Аудитын гол асуудал**

“Ди Ти Эм Строй” ХХК, “Бумбах” ХХК-р 273.3 сая төгрөг болон 27.2 сая төгрөг, нийт 300.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй их засварыг гүйцэтгүүлсэн.

**Бусад асуудлын хэсэг**

Хөвсгөл аймгийн Биеийн тамир спортын газрын дарга нь гүйцэтгэлийн тайлангаа үнэлүүлж, хангалттай үнэлгээ авсан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **47,212,811.26** | **123,235,829.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.00 | 47,500.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 00.00 | 47,500.00 |
| **3121** | **Төгрөг** | 00.00 | 47,500.00 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 00.00 | 47,500.00 |
| **33** | **АВЛАГА** | 599,611.26 | 00.00 |
| **335** | **Бусад авлага** | 599,611.26 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 599,611.26 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 46,613,200.00 | 123,188,329.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 27,936,100.00 | 58,506,429.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 27,936,100.00 | 58,506,429.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 18,677,100.00 | 64,681,900.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 626,100.00 | 1,103,400.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 771,400.00 | 1,222,800.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 00.00 | 2,644,300.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 9,827,700.00 | 34,247,500.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 7,451,900.00 | 25,463,900.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,934,023,189.60** | **4,025,251,591.40** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3,934,023,189.60 | 4,025,251,591.40 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,952,381,939.60 | 3,043,985,341.40 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,358,087,891.19 | 2,658,715,441.19 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -237,031,861.32 | -316,284,945.36 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 33,600,000.00 | 33,600,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -8,866,666.73 | -14,466,666.77 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 73,575,220.82 | 73,575,220.82 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -3,070,526.90 | -24,690,237.98 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 7,560,500.00 | 7,560,500.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -885,282.90 | -2,088,999.78 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,161,772,812.00 | 1,176,772,812.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -432,360,146.56 | -548,707,782.72 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 981,641,250.00 | 981,266,250.00 |
| 39301 | Програм хангамж | 2,050,000.00 | 2,050,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -581,250.00 | -956,250.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 980,172,500.00 | 980,172,500.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,981,236,000.86** | **4,148,487,420.40** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **47,500.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 47,500.00 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 47,500.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 00.00 | 47,500.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 00.00 | 47,500.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,981,236,000.86** | **4,148,439,920.40** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,981,236,000.86 | 4,148,439,920.40 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,149,478,579.00 | 2,149,478,579.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 2,149,478,579.00 | 2,149,478,579.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 582,252,026.13 | 749,455,945.67 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 582,252,026.13 | 582,252,026.13 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 167,203,919.54 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,249,505,395.73 | 1,249,505,395.73 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,981,236,000.86** | **4,148,487,420.40** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **598,488,920.82** | **1,046,206,250.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **65,161,320.82** | **330,627,550.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 65,161,320.82 | 330,627,550.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 65,161,320.82 | 330,627,550.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 295,800.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 64,865,520.82 | 330,627,550.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **210,418,500.00** | **715,578,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 00.00 | 423,117,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 423,117,400.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 322,909,100.00 | 00.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 46,944,000.00 | 57,854,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 46,944,000.00 | 55,630,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 2,224,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 163,474,500.00 | 234,606,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 163,474,500.00 | 234,606,800.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **723,667,102.83** | **879,002,330.46** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **723,667,102.83** | **879,002,330.46** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 701,046,753.56 | 854,698,812.15 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 235,988,351.04 | 244,512,740.51 |
| 210101 | Үндсэн цалин | 235,988,351.04 | 188,718,482.17 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 23,677,980.84 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 19,570,000.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 12,546,277.50 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 30,549,878.33 | 30,547,187.14 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,408,504.33 | 21,008,352.68 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,359,873.00 | 2,443,364.17 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,887,897.00 | 1,954,691.13 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 436,775.00 | 455,562.39 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,456,829.00 | 4,685,216.77 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 140,945,138.37 | 143,670,162.30 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,401,960.37 | 5,147,304.42 |
| 210302 | Түлш, халаалт | 135,000,000.00 | 134,400,497.88 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,543,178.00 | 4,122,360.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 18,225,799.00 | 18,201,595.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 858,400.00 | 2,072,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,500,000.00 | 2,860,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 803,594.00 | 1,464,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 70,500.00 | 98,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,511,805.00 | 5,832,095.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 5,481,500.00 | 5,874,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,802,700.00 | 12,419,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 240,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,562,700.00 | 12,419,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 768,000.00 | 2,272,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 768,000.00 | 2,272,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,670,500.00 | 2,941,624.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 98,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 540,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 119,250.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 00.00 | 49,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 00.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 481,000.00 | 415,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 3,189,500.00 | 1,686,874.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 258,096,386.82 | 400,134,503.20 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 53,448,000.00 | 173,833,355.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 1,902,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 204,648,386.82 | 224,399,148.20 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 22,620,349.27 | 24,303,518.31 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 16,439,000.00 | 18,431,900.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 15,939,000.00 | 16,966,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 500,000.00 | 1,465,000.00 |
| **2134** | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 6,181,349.27 | 5,871,618.31 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **125,178,182.01** | **167,203,919.54** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **125,178,182.01** | **167,203,919.54** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,149,478,579.00** | **1,249,505,395.73** | **582,252,026.13** | **3,981,236,000.86** |
| D01 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,149,478,579.00** | **1,249,505,395.73** | **582,252,026.13** | **3,981,236,000.86** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,149,478,579.00** | **1,249,505,395.73** | **582,252,026.13** | **3,981,236,000.86** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 167,203,919.54 | 167,203,919.54 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,149,478,579.00** | **1,249,505,395.73** | **749,455,945.67** | **4,148,439,920.40** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **546,743,400.00** | **715,626,200.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **295,800.00** | **47,500.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 295,800.00 | 47,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 295,800.00 | 00.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 295,800.00 | 00.00 |
| 120009 | Бусад орлого | 00.00 | 47,500.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **546,447,600.00** | **715,578,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 00.00 | 423,117,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 423,117,400.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 322,909,100.00 | 00.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 60,064,000.00 | 57,854,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 60,064,000.00 | 55,630,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 2,224,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 163,474,500.00 | 234,606,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 163,474,500.00 | 234,606,800.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **526,182,050.73** | **709,707,081.69** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **526,182,050.73** | **709,707,081.69** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **509,743,050.73** | **691,275,181.69** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 235,988,351.04 | 244,512,740.51 |
| 210101 | Үндсэн цалин | 235,988,351.04 | 188,718,482.17 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 23,677,980.84 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 19,570,000.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 12,546,277.50 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 30,378,762.32 | 30,547,187.14 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,318,900.00 | 21,008,352.68 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,327,562.32 | 2,443,364.17 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,795,300.00 | 1,954,691.13 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 448,800.00 | 455,562.39 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,488,200.00 | 4,685,216.77 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 140,945,138.37 | 143,070,551.04 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,401,960.37 | 5,147,304.42 |
| 210302 | Түлш, халаалт | 135,000,000.00 | 133,800,886.62 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,543,178.00 | 4,122,360.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,123,199.00 | 12,126,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,000,100.00 | 2,523,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,947,600.00 | 2,860,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 803,594.00 | 1,464,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 70,500.00 | 98,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,301,405.00 | 5,180,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 19,287,700.00 | 57,495,100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 240,000.00 | 00.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 203,800.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 18,843,900.00 | 57,495,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 768,000.00 | 2,368,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 768,000.00 | 2,368,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,670,500.00 | 2,991,624.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 148,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 540,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 119,250.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 00.00 | 49,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 00.00 | 33,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 481,000.00 | 415,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 3,189,500.00 | 1,686,874.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 71,581,400.00 | 198,163,379.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 71,581,400.00 | 196,261,379.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 1,902,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **16,439,000.00** | **18,431,900.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 16,439,000.00 | 18,431,900.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 15,939,000.00 | 16,966,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 500,000.00 | 1,465,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **20,561,349.27** | **5,919,118.31** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **14,380,000.00** | **00.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **14,380,000.00** | **00.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 14,380,000.00 | 00.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 14,380,000.00 | 00.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-14,380,000.00** | **00.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 6,181,349.27 | 5,919,118.31 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 47,500.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 423,117,400.00 | 420,796,672.62 | -2,320,727.38 | 99.45 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 423,117,400.00 | 420,796,672.62 | -2,320,727.38 | 99.45 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 404,685,500.00 | 402,364,772.62 | -2,320,727.38 | 99.43 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 217,623,400.00 | 216,909,117.86 | -714,282.14 | 99.67 |
| 210101 | Үндсэн цалин | 152,383,800.00 | 165,018,131.92 | 12,634,331.92 | 108.29 |
| 210102 | Нэмэгдэл | 31,885,300.00 | 22,079,708.44 | -9,805,591.56 | 69.25 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 18,900,000.00 | 17,265,000.00 | -1,635,000.00 | 91.35 |
| 210104 | Урамшуулал | 14,454,300.00 | 12,546,277.50 | -1,908,022.50 | 86.80 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 27,202,900.00 | 27,172,551.76 | -30,348.24 | 99.89 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,498,000.00 | 18,630,109.19 | 132,109.19 | 100.71 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,176,200.00 | 2,167,327.97 | -8,872.03 | 99.59 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,741,000.00 | 1,733,862.19 | -7,137.81 | 99.59 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 435,200.00 | 410,150.85 | -25,049.15 | 94.24 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,352,500.00 | 4,231,101.56 | -121,398.44 | 97.21 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10,444,100.00 | 10,390,100.00 | -54,000.00 | 99.48 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,372,800.00 | 1,323,000.00 | -49,800.00 | 96.37 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,860,000.00 | 2,860,000.00 | 0.00 | 100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,464,300.00 | 1,464,300.00 | 0.00 | 100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 98,800.00 | 98,800.00 | 0.00 | 100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,648,200.00 | 4,644,000.00 | -4,200.00 | 99.91 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,381,000.00 | 2,368,000.00 | -13,000.00 | 99.45 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,381,000.00 | 2,368,000.00 | -13,000.00 | 99.45 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,179,000.00 | 2,991,624.00 | -1,187,376.00 | 71.59 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,140,000.00 | 148,000.00 | -992,000.00 | 12.98 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 540,000.00 | 540,000.00 | 0.00 | 100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 120,000.00 | 119,250.00 | -750.00 | 99.38 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,000.00 | 49,500.00 | -30,500.00 | 61.88 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 33,000.00 | 0.00 | 100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 500,000.00 | 415,000.00 | -85,000.00 | 83.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,766,000.00 | 1,686,874.00 | -79,126.00 | 95.52 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 142855100.00 | 142533379.00 | -321,721.00 | 99.77 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 140,953,100.00 | 140,631,379.00 | -321,721.00 | 99.77 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,902,000.00 | 1,902,000.00 | 0.00 | 100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 18431900.00 | 18431900.00 | 0.00 | 100.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 18,431,900.00 | 18,431,900.00 | 0.00 | 100.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 16,966,900.00 | 16,966,900.00 | 0.00 | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,465,000.00 | 1,465,000.00 | 0.00 | 100.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 423,117,400.00 | 420,796,672.62 | -2,320,727.38 | 99.45 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 423,117,400.00 | 420,796,672.62 | -2,320,727.38 | 99.45 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 423,117,400.00 | 420,796,672.62 | -2,320,727.38 | 99.45 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 47,500.00 | 47,500.00 | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 23.00 | 23.00 | 0.00 | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 10.00 | 10.00 | 0.00 | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 12.00 | 12.00 | 0.00 | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **57,366,500.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **57,366,500.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 57,366,500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,736,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,200,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 536,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 55,630,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 55,630,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 57,366,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 57,366,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 55,630,000.00 |

| | | |
|---|---|---|
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,736,500.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөвсгөл аймгийн Биеийн тамир, спортын газар нь аймгийн биеийн тамир, спортыг хөгжүүлэн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа явуулдаг Биеийн тамир спортын Улсын Хорооны харьяа байгууллага юм.

### 3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд: “Биеийн тамир, спортын тухай хууль”, “Биеийн тамирын спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”, “Төрөөс биеийн тамирын спортын талаар баримтлах бодлого”, Сангийн сайдын тушаалууд, “Нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх Засгийн газрын 05 дугаар тогтоол”, “Монгол улсын ерөнхийлөгчийн зарлиг”, “Биеийн тамир спортын улсын хорооны даргын 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/26 дугаар тушаал”, Аймгийн Засаг даргын А/87 захирамжийн дагуух “Илүүдэл жингүй Эрүүл иргэнтэй Хөвсгөл аян”, БТСУХ-ны №1/693 тоот-Биеийн тамир спортын тухай хуулийн 17,3 дахь заалтын дагуух Улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах нэгдсэн хуваарь заавryг мөрдлөг болгон ажиллаж байгаа бол “Эрүүл мэндийн даатгалын тухай хууль”, “Хөдөлмөрийн тухай хууль”, “Нийгмийн даатгалын тухай хууль”-д орсон өөрчлөлтийг даган мөрдөж байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьаар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн суурьаар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Биеийн тамир, спортын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 167.2 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Дансны авлага | 0.6 | - | (0.6) |
| Бараа материал | 46.6 | 123.1 | 76.5 |
| Үндсэн хөрөнгө | 3,934.0 | 4,025.2 | 91.2 |
| Биет бус хөрөнгө | 981.6 | 981.2 | (0.4) |
| **Нийт хөрөнгө** | **3,981.2** | **4,148.4** | 167.2 |
| Дансны өглөг | - | 0.04 | 0.04 |
| -төрийн | 2,149.4 | 2,149.4 | - |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 1,249.5 | 1,249.5 | - |
| Хуримтлагдсан үр дүн | 582.2 | 749.5 | 167.0 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **3,981.2** | **4,148.4** | 167.2 |

Тайлант онд дараах данстад өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Дансны авлага 0.6 сар төгрөгөөр багассан бол өглөг 0.04 сая төгрөгөөр өссөн байна.
2. Бараа материал 76.6 сая төгрөгөөр өссөн нь Спортын ордны оффисын өрөө , туслах 4 зал, том залны дээврээс дусаал гоожиж мөөгөнцөртөж тамирчин хүүхдүүд бэлтгэл сургуулилт хийх боломжгүй болж урсгал засварын зардлаас засвар хийсэн. Мөн байгууллагын паар цоорч , 00-ийн өрөөнүүдийн бохирын шугам бөглөрч 00-ийн суултуур угаалтуурыг бүрэн сольж , Улсын аварга шалгаруулах тэмцээн уралдаанд оролцох болон аймгийн аварга шалгаруулах тэмцээнд зарцуулагдах 35,6 сая төгрөгийн спортын хэрэглэгдэхүүн материалыг худалдан авсан нь нөлөөлжээ.
3. Үндсэн хөрөнгө данс 91.2 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд Барилга байгууламжийн бүртгэлийн хувьд " Ди Ти Эм Строй" ХХК, "Бумбах" ХХК-р гүйцэтгүүлсэн их засвараар үндсэн хөрөнгийг капиталжуулсан. Мөн аймгийн Иргэдийн Хурлын Төлөөлөгчдийн 2022 оны 12 сарын 02-ны дугаар № 03-р тогтоолоор Спортын ордны гадна талбайд байгаа 3 аваргын хөшөөг нэг бүрийг 5,0 сая төгрөгөөр тооцоолж 15,0 төгрөгөөр бүртгэж бүртгэлд тусгасан зэрэг нь нөлөөлсөн.
4. Хуримтлагдсан үр дүн 167.3 сая төгрөгөөр өссөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,150.1 сая, нийт зарлагыг 1,150.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 492.4 сая төгрөгөөр бууруулж, 657.7 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 423.1 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсан. Орон нутгийн төсвөөс 57.3 сая төгрөгөөр санхүүжсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 420.7 сая төгрөг буюу 99.4 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний зардал*

/сая төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| | Биеийн тамирын хөтөлбөр | 657.7 | 652.2 | -5.5 | 99.16% |
| 1 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 516.8 | 511.6 | -5.2 | 98.99% |
| 2 | Биеийн тамир уралдаан тэмцээний зардал | 140.9 | 140.6 | -0.3 | 0.17% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 57.8 сая төгрөгийн нэмэлт орлого хүлээн авч тайлагнасан байна.

Үнээс хангамж, бараа материалын зардалд 1.7 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 55.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Биеийн тамир, спортын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан Соёмбо Аудит ХХК-ийн чанарын хяналт, ахлах аудитор Н.Бадамханд гүйцэтгэж, хяналтыг анхан шатанд Хаан Соёмбо Аудит ХХК-ийн захирал Х.Диймаа, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор Б.Даваанямъ, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Биеийн тамир, спортын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар буюу 14.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 10.1 сая төгрөгөөр тогтоосон.
Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянахад дараах зөрчил илэрч байна. Үүнд: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 4.1 сая төгрөгийн 1 орлогын гүйлгээг мэдээлээгүй, 4.8 сая төгрөгийн гүйлгээг дутуу мэдээлсэн, зарлагын 13.3 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.4, 6.4.5 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.2.9, 3.2.10 дахь заалттай тус тус нийцэхгүй байгаа бөгөөд “Иж бүрэн” байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд хянаж үзэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Биеийн тамир спортын газрын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх онд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж хүргүүлээгүй байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 0 | 0.0 | 0 | | |
| **Нийт дүн** | **0** | 0.0 | 0 | | |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар онцгойлон үзэх асуудал байхгүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 24.3 сая төгрөгийн зөрчил[1] -ийг илрүүлж, дахин давтахгүй байх зөвлөмж хүргүүлсэн.

Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой залруулга хийгдээгүй болно.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй болно.

5.3 Зөвлөмж

**1. Бараа материалтай холбоотой асуудал**

***Илрүүлэлт:***

Анхан шатны баримтын бүрдэлгүй 1.6 сая төгрөгийн зарцуулалт хийсэн, И баримтаар баталгаажаагүй 0.3 сая төгрөгийн худалдан авалт хийж, нягтлан бодох бүртгэлд тусгасан

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7[2] дах заалтыг зөрчсөн ба "Иж бүрэн" байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

***Өгсөн зөвлөмж:***

Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийж тайлагнахгүй байх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Анхан шатны баримт дутуу | 2 | 1.8 | | | | | 1 | 1.8 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Мэдээлээгүй | 3 | 22.4 | | | | | 1 | 22.4 |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО: 3/28

АУДИТОР Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ Х.ДИЙМАА

ЧАНАРЫН ХЯНАЛТ, АХЛАХ АУДИТОР Н.БАДАМХАНД

[2] Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.